

ӨВӨРМӨЦ ХЭЛЦ ХЭЛЛЭГ ХЭЛ ОРОН СУДЛАЛЫН ИЛЭРХИЙЛЭЛ БОЛОХ НЬ

Б. Боргилмаа¹

Олон улсын харилцаанд чухал үүрэг гүйцэтгэж байгаа зүйлүүдийн нэг бол хэл юм. Тухайн орон бүрийн хэлээр харилцах хүмүүсийн дунд өрнөх харилцаанд хэлний янз бүрийн нэгжүүд өргөн хэрэглэгддэг. Тэр хэлээр харилцагч ард түмний зан заншил, уламжлал, түүх, соёл, шашин шүтлэг, ертөнцийг үзэх үзэл, сэтгэлгээ зэрэг бүгд л ямар нэгэн байдлаар хэлэнд нь шингэсэн байдаг. Тийм ч учраас улс орон бүрийн онцлогуудыг таних түлхүүр бол хэл гэж үздэг. Хэлээр нь дамжиж соёлыг нь, ёс заншлыг нь, уламжлалыг нь таньж мэдэж болох юм. Тиймээс л манай монголчууд хэлтэй бол хөлтэй гэлцдэг. Хэлний олон нэгж дотроос орон судлалын утга агуулгыг илүүтэй шингээсэн нэгж бол үндэсний онцлог үгс дотор багтах өвөрмөц хэлц хэллэг билээ. Хэлний өргөн хэрэглээ болох хэлэхүйн харилцаанд өнгө, үнэр, амт оруулж чимж өгдөг зүйл бол өвөрмөц хэлц хэллэг юм. Өөрөөр хэлбэл тухайн орны өвөрмөц хэлц, хэллэгийг мэддэг төдийгүй харилцаандаа онож хэрэглэх нь тэрхүү харилцаанд амт, үнэр, өнгө оруулж буй хэрэг мэт санагдана. Энэ тухай манай нэрт зохиолч, орчуулагч Ц.Дашдондов гуай “Аливаа хэлний аль сайхан амт чанар, шим шүүс шингээстэй хэсэг нь өвөрмөц хэлц хэллэг, зүйр цэцэн үг, сургааль үгс юм. Зүйрлэвээс цайны бол дээж нь, сүүний бол өрөм нь, шөлний бол тослог нь, цэцгийн бол бал нь”² хэмээн тодорхойлсон байдаг.

Орчин үед өвөрмөц хэлц хэллэгийг дан ганц хэл шинжлэл төдийгүй орон судлал, хүн судлал, соёл судлал, нийгэм хэл шинжлэл, сэтгэл хэл шинжлэл, угсаа хэл шинжлэл, танихуйн хэл шинжлэл зэрэг олон шинжлэх ухааны уулзвар дээр авч үзэн судлахын чухлыг эрдэмтэн судлаачид тэмдэглэсэн байдаг. Тухайлбал, “Аливаа үндэстний хэл бол тэр төрөлх хэлтний соёлынх нь хэл байдаг учраас хэлийг үндэстэн-соёл, соёл-үндэстний өвөрмөц онцлог, оюун санааных нь уламжлан тогтсон хэв шинж (эталон, стереотипность)³-ийн үүднээс судлах хандлагатай болоод байна. Ялангуяа дэлхийн янз бүрийн бүс нутагт эртнээс аж төрж, өөр өөр хэлээр ярьдаг, эдийн болон оюуны өвөрмөц соёлыг бүтээн уламжилж ирсэн улс үндэстнүүд бие бие рүүгээ ойртон тэмүүлцгээх болсон энэ цагт ийм судалгаа чухал ач холбогдолтой төдийгүй дараагийн эрин зуунд хүмүүнлэгийн шинжлэх ухааны үүрэг, ач холбогдол хэзээ

¹ МУИС-ийн ОУХС-ийн багш

² Ц. Дашдондов Монгол- Англи өвөрмөц хэлц, хэллэгийн толь – Уб., 2001, 16 тал

³ В. И.Телия. Русская фразеология. Семантический, прагматический и лингвокультурологический аспекты. М., 1996

хэзээнийхээс илүү ач холбогдолтой болох нь магадгүй”⁴ гэж тэмдэглэжээ.

Өвөрмөц хэлц хэллэгийн тухай Англи, Америк, Орос, Япон зэрэг дэлхийн олон орны эрдэмтэн судлаачид өөр өөрийн судалгааны өнцгөөс харж судалгаа шинжилгээний ажлаа явуулж байна. Үүнтэй мөр зэрэгцэн манай эрдэмтэн судлаачид монгол өвөрмөц хэлц хэллэгээр тухайлан ганц сэдэвт бүтээл, толь бичиг туурвиж, эрдмийн зэрэг хамгаалсан болон бусад орны өвөрмөц хэлц хэллэгтэй харьцуулсан ба зэрэгцүүлсэн судалгаа хийсэн нь олон байдаг. Тухайлбал, **үгийн сангийн түвшинд** Ж.Төмөрцэрэн, Ц.Өлзийхутаг, Г.Аким зэрэг судлаач, эрдэмтэд судалсан бөгөөд эрдэмтэн Ж.Төмөрцэрэн монгол хэлний өвөрмөц хэлцийн үгийн бүрэлдэхүүнийг зүйлчлэн ангилах, судлан тогтоох анхны оролдлогыг хийсэн. Эрдэмтэн Ц.Өлзийхутаг чөлөөт нийлэмж үг, хэлц үг болон өвөрмөц хэллэг, хэвшмэл хэллэгийн ялгааг судалж тогтоожээ. Судлаач Г.Аким өвөрмөц хэлцийг бүтцийн хувьд өгүүлбэртэй тэнцэх хэлц, бүтцээрээ нийлэмж үгийн маягтай хэлц гэж хоёр ангилжээ.

Өвөрмөц хэлцийг **орчуулах талаар** профессор Чой.Лувсанжав “... *утгыг голлох бөгөөд хэрэгтэй гэсэн газар үгчилж, утгачилсан орчуулгыг хавсаргах нь зүйтэй юм*”⁵ гэж өвөрмөц хэлцийн орчуулгын толь бичгийн урьтал хэсэгтээ бичсэн байдаг. Эрдэмтэн Д.Дашдаваа хэлц үг, зүйр цэцэн үгийг хэрхэн орчуулах арга зүйн талаар судалсан бол судлаач Г.Аким өвөрмөц хэлцийг бүрэн ба заримдаг дүйх гэж хоёр хуваадаг гэж үзсэн.

Өвөрмөц хэлцийг **утгазүйн хүрээнд** тусгайлан судалсан эрдэмтэн бол профессор Д.Бадамдорж бөгөөд “*Өвөрмөц хэлц гэдэг бол утгын хувьд бүрдүүлж байгаа үг тус бүрийн цөм утга алдарч, нийлэн нэгдэж, нэгэн ухагдахуун, утга санаа илэрхийлсэн, тухайн ард түмний сэтгэхүй, сэтгэлгээ нэвт шингэсэн, аж ахуй, бодот амьдрал, хэв ёс, зан заншил, шаашин шүтлэг, үзэл бодол гэх зэргийн гүн тусгал болсон тогтвортой нийлэмж үг юм*”⁶ хэмээн тодорхойлоод өвөрмөц хэлцийг утгын олон төв болгон ангилж судалсан.

Өвөрмөц хэлц, хэллэгийг **тользүйн хүрээнд** профессор Чой.Лувсанжав (1970 онд), Г.Аким (1982, 1985, 1995, 1999 онд), Ц.Дашдондов (1987, 1992, 2001, 2003, 2007 онд), Ж.Бат-Ирээдүй (2007 онд) нар орос, англи хэлнээс орчуулан, Л.Чулуунбаатар, Ц.Онон (2009 онд) япон хэлнээс монгол хэл рүү тус тус хөрвүүлэн толь бичиг туурвижээ. Харин Л.Дашням, Д. Намуун (2005 онд), Ж.Бат-Ирээдүй (2009 онд), А.Пүрэвжанцан (2010 онд) нар тусгайлан монгол хэлний өвөрмөц хэлц, хэллэгийн толь бичиг туурвижээ.

1966 онд профессор Чой.Лувсанжав “Монгол хэлний өвөрмөц хэлц” хэмээх ганц сэдэвт зохиол бичиж, хэл бичгийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалжээ. 2000 онд И.Өнөрзул “Орчин цагийн монгол хэлний хэлцийн өгүүлбэр зүйн бүтэц, тогтолцоо ба утга”, 2004 онд Ц.Түмэндэмбэрэл “Монголын нууц товчооны хэлцийн судалгаа”, 2010 онд Л.Ганчимэг “Монгол хэлний хэлц нэгжийн бүтэц-утга зүйн тогтолцоо” хэмээх бүтээл туурвиж докторын зэрэг тус тус хамгаалжээ. Монгол хэлний өвөрмөц хэлц, хэллэгийг орон судлалын үүднээс эрдэмтэн судлаачид тодорхой хэмжээгээр судалгаандаа оруулаад цаашид хэл орон судлал, соёл шүтэлцээний үүднээс судлах хэрэгцээ шаардлагын тухай тэмдэглэсэн байдаг. Тухайлбал,

⁴ Ж. Баянсан Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ – Уб., 2002, 82-83 тал

⁵ Чой. Лувсанжав Орос монгол өвөрмөц хэллэгийн толь – Уб., 1970, 3 тал

⁶ Д. Бадамдорж Монгол хэлний утгасудлал, –Уб., 2001. 32-84 тал

Профессор Чой.Лувсанжав “Ер нь өвөрмөц хэллэг гэдэг бол гагцхүү тухайн үндэстний хэлэнд буюу тухайн соёлын хүрээнд багтах улсын хэлэнд байдаг бүрэлдүүлсэн үгсий нь утга алдраад нэгэн нэгдмэл утга гаргах болсон тогтворжмол нийлмэл үгийн нэр юм. Энгийн арав хорин үгээр гаргах санааг ганц хоёрхон үгэнд хураагаад хүний ой ухаанд тов тод оруулж өгөх ид чадал чухамхүү хэл хэлний өвөрмөц хэллэгт л байдаг юм. “Туранхай тэмээ”-г “хана үдмээр тэмээ” гэдэг нь тэмээнийхээ үдээрээр ханаа үддэг малчин монгол хэлэнд л байдаг юм шиг байна”⁷ хэмээн өвөрмөц хэлц нь орон судлал, үндэстний соёлын онцлогийг агуулдаг талаар судалгаандаа тэмдэглэсэн байдаг.

Өвөрмөц хэлц, хэллэгүүд нь тухайн ард түмний уламжлалт аж төрөх ёс, зан заншил, шашин мөргөл, үндэсний сэтгэлгээний онцлогоос шалтгаалан хэл тус бүрт өөр өөр шинжтэй байдаг байна. Тодруулан хэлвэл, өвөрмөц хэлц, хэллэгүүд нь улс үндэстэн бүрийн ахуй амьдрал, дадал заншлыг нарийн тусгадгаас гадна тухайн хэлний сэтгэн дүрслэх арга маяг, илэрхийлэн гаргах ур чадвараас шалтгаалан нэгэн адил утга санааг өөр өөрөөр дүрслэн, нэгэн тодорхой юмыг өөр өөр зүйлээр төлөөлүүлэн гаргадаг онцлогтой. Тийм учраас өвөрмөц хэлц, хэллэгийн судлал нь тухайн улс үндэстний хэл соёлын уламжлал, сэтгэлгээний онцлог шинж, түүхэн харилцаа холбоо хийгээд соёлын сав хүрээ зэргийг улируулан судлахад нэн чухал ач холбогдолтой.⁸

Өвөрмөц хэлц гэж хоёроос дээш үгээс бүтсэн нэгэн нэгдмэл утга санааг гүн гүнзгий уран тод амьд дүрслэн илтгэж, үндэстний соёлын өв, мэдлэг туршлага сургамжийг уламжлуулдаг хэлний үндсэн тогтвортой нэгж мөн.

Энэхүү өгүүлэлдээ япон хэлний зарим өвөрмөц хэлцийг сонгон авч, хэл орон судлалын үүднээс үндэстний сэтгэлгээний онцлогийг тодруулах зорилго тавьлаа.

Хэл-орон судлал үгийн утгад шингэсэн үндэсний соёлын бүрэлдэхүүнийг юуны өмнө судалдаг.⁹ Өвөрмөц хэлцийг тухайн үндэстний соёлын тусгал ч гэж үздэг. Энэ нь тухайн өвөрмөц хэлцийн үүсэл гарал, хэрэглээ, утгад ил ба далд байдлаар заавал холбоотой байдаг. Энэ удаагийн өгүүлэлдээ япон үндэстний өдөр тутмын амьдралд өргөн хэрэглэгддэг хэлцүүд дотроос сонин, сэтгүүл, телевизийн нэвтрүүлгээс нийт 30 гаруйг түүвэрлэн сонгон авч ажиглалт хийлээ. Жишээлбэл:

牛耳る (үхрийн чихийг барих) удирдах, эрхлэх, хяналт тавих, гартаа авах¹⁰ голлох үүрэг гүйцэтгэх гэсэн утгатай.

Хятадын урт хугацааны аян дайны үеийн “春秋左氏伝” бичгийн дурсгалд “執牛耳” (үхрийн чихийг барих) хэмээн тэмдэглэгдсэн үгээс гаралтай бөгөөд Мэйжигийн үед үүссэн этгээд үг хэллэг юм. “牛耳を執る” гэдэг нь тухайн үеийн ноёдууд тангараг өргөхдөө үхрийн чихийг тасалж, цусыг нь сорж уун бурханд хандаж ам тангараг өргөдөг байжээ. Энэ ёсыг тэргүүн ноёдууд хэрэглэх болсноос хойш ямар нэгэн бүлэг эвлэл зэргийг ахлаж буй хүн, мөн хурал цуглааныг зохион байгуулах, удирдах гэсэн утгаар хэрэглэгдэх болжээ. Одоо ч гэсэн улс төрийн үг хэллэгт өргөнөөр хэрэглэгдэг.

首になる (хүзүү болох) ажлаас халагдах, толгойгоо авахуулах¹¹

⁷ Чой. Лувсанжав Орос монгол өвөрмөц хэллэгийн толь – Уб., 1970, 3 тал

⁸ Ц. Дашидондов Монгол- Англи өвөрмөц хэлц, хэллэгийн толь – Уб., 2001, 3-4 тал

⁹ Эрдэм шинжилгээний бичиг, боть 170(1), МУИС-ГХСС – Уб., 2001, 17 тал

¹⁰ С.Дэмбэрэл Япон –Монгол толь бичиг-Уб., 2010, 270 тал

¹¹ С.Дэмбэрэл Япон –Монгол толь бичиг-Уб., 2010, 309 тал

Японы үндэсний театрын урлагийн нэг болох хүүхэлдэйн ший жүжгээс үүдэлтэй. Энэхүү жүжигт тоглох хүүхэлдэйгээр хүний үйлдэх бүхий л хөдөлгөөн, сэтгэлийн өнгө аясыг илэрхийлж гаргахын тулд хүүхэлдэйн их биеийг нэг хүн, гар хөлийн хөдөлгөөнийг тус бүр хоёр, нийлээд гурван хүн тоглуулдаг.

Тухайн хүүхэлдэйн дүр тоглогдож дуусахаар жүжигчид хүүхэлдэйн их биеэс толгойн хэсгийг хүзүү хэсгээр нь салгаад өрөөндөө өлгөж тавьдаг. Ийнхүү тухайн хүүхэлдэйн тоглох дүр дууссаныг “толгой цавчих”, “толгойгоо авахуулах” хэмээн нэрлэдэг байснаас энэхүү хэлц үүсжээ. Хүүхэлдэйн дүр дуусах үзэгдэл орчин үед японы нийгэмд өргөн хэрэглэгддэг. Тодорхой ажил үүрэг гүйцэтгэж байгаад тухайн үүрэгт ажлаасаа халагдахыг ингэж хэлдэг.

見えを切る (сүр үзүүлэх) өөрийгөө дөвийлгөх, магтах

見え- 1. гайхуулах, ихэрхүү зан, сүр, байдал, дүр

2. кабуки-д гол хэсгийн олны анхаарал татах тоглолт¹²

Анх Японы сонгодог драмын жүжиг Кабуки театрын гоцлол жүжигчдэд зориулсан үзэгчдийн суудлаас голын тайз руу орж ирдэг 花道 “цэцгэн зам” хэмээн нэрлэдэг хэсэгт гол дүрийн жүжигчин гарч ирэн онцгой уран үзүүлбэр үзүүлэхийнхээ өмнө поз авч зогсохыг хэлдэг байсан хэллэгээс гаралтай. Гол дүрийн жүжигчин энэхүү замаар тайзан дээр гарч ирж, бас тайзыг орхидог. Цэцгэн зам ч мөн адил тоглолт үзүүлэх талбар тул гол дүрийн жүжигчин гайхуулам онцгой үзэгдлийг үзүүлдэг байдал японы нийгэмд ихэрхүү зан, өөрийгөө дөвийлгөх, сүр дүр үзүүлэхийг илэрхийлэх өвөрмөц хэлц хэллэг болжээ.

犬死にをする (нохойн үхлээр үхэх) дэмий зүйл¹³

Дайн тулааны газар жад ч атугай зоолгүйгээр, амиа алдахыг самурай нар нэр төрөө дуурсгах үхэл гэж тооцдоггүй төдийгүй нохойн үхэлд тооцож, хэрэв ийм үхлээр үхсэн тохиолдолд сул доройн шинж хэмээн үздэгээс энэхүү хэлц үүсчээ.

腹を切る (гэдсээ хүүлэх) хариуцлага хүлээн ажлаа өгөх, огцрох¹⁴

Японд дундад зууны үед эхэлж, самурай нар гэмт үйлдлээ хүлээн өршөөлийг эрэн, ичгүүр шившгээс зайлж, найз нөхдөө авран, өөрийнхөө үнэнчийг батлах арга болж гэдсээ хүүлдэг байжээ. Энэхүү үйлдэл нь орчин үед гэдсээ хүүлэх бус хариуцлага хүлээх, ажлаа сайн дураараа өгөх, үүргээ ухамсарлах гэсэн утгаар Японы нийгэм, ялангуяа улс төрийн ертөнцөд өргөн хэрэглэгддэг өвөрмөц хэлц юм.

油を売る (тос худалдах) цаг нөгцөөх, дэмий байх¹⁵

Японы Эдогийн үе (1603-1867 он) -д тос худалдагч тосоо худалдангаа дугаарлан зогсож байгаа хүмүүстэй янз бүрийн зүйлийг ярьж, хүлээж зогсоо хүмүүс ч хоорондоо ярилцан цаг нөгцөөдөг байснаас энэхүү хэлц үүссэн. Орчин үед Японы өдөр тутмын амьдралд цаг нөхцөөхөөр гадагшаа гарахыг ийнхүү хэлдэг.

駄目を押す (болохгүй зүйлийг тулгах) дахин нягтлах, итгэлтэй мэдэж байгаа зүйлээ дахин лавлаж шалгах¹⁶

¹² С.Дэмбэрэл Япон – Монгол толь бичиг-Уб., 2010, 1154 тал

¹³ Л. Чулуунбаатар, Ц. Онон Япон монгол хэлний өвөрмөц хэлцийн толь – Уб., 2010, 36 тал

¹⁴ С.Дэмбэрэл Япон – Монгол толь бичиг-Уб., 2010, 990 тал

¹⁵ С.Дэмбэрэл Япон – Монгол толь бичиг-Уб., 2010, 29 тал

¹⁶ С.Дэмбэрэл Япон – Монгол толь бичиг-Уб., 2010, 719 тал

Япон үндэсний “Го” хэмээх дааманд хоёр талын зааган дундах төвийн орон зайг хэлдэг ба энэ зайнд ямар байр суурьтай байгаагаас шалтгаалан тоглоомонд ялах эсвэл ялагдах нь тодорхой болдог ба үүнээс энэ утга үүссэн байна.

腐っても鯉 (өмхийрсөн ч мөрөг загас) хуучирч, муудсан ч мөрөг загас бол мөрөг загас. Энэ нь сайн зүйл бол үнэ цэнээ хэзээ ч алддаггүй гэсэн утгатай. Япон үндэстний хувьд мөрөг загас нь эр зориг, эрч хүч бэлэгдсэн загас юм. Тийм болохоор япончууд идээ ундааны дээж хэмээн мөрөг загасыг зочин гийчиндээ зориулан мөрөг загасаар зоог бэлдэн дайлдаг уламжлалтай. Мөн энэ хэлцийг муу ч гэсэн эр хүн гэдэг утгаар хэрэглэж бас болно. Манай монголчуудын эр хүн, эцэг хүнийг дээдэлдэг сэтгэлгээтэй төстэй санагдсан.

ふぐは食いたい命は惜しい (Фүгү идмээр амь хайран) алийг нь сонгохооо мэдэхгүй салаа зам дээр байгаа эргэлзсэн санаагаа ийнхүү хэлдэг.

Фүгү гэж бөмбөрцөг загас буюу хортой загас. Маш амттай, хүний биед сайн гэж япончууд ярьдаг төдийгүй хүндэтгэлийн идээнд ордог загас.

花より団子 (цэцэгнээс цагаан будааны боов дээр) маргаашийн өөхнөөс өнөөдрийн уушиг дээр

Өмнөө тулгараад байгаа бодит зүйлүүдээс өөртөө хамгийн хэрэгтэй гэж үзэх зүйлээ сонгог гэсэн утга санааг илэрхийлдэг. 団子(данго) гэж цагаан будааны гурилыг бөөрөнхийлж жигнэсэн боовыг хэлнэ. Тиймээс цэцэг авснаас аяга хоол авч идсэн нь дээр гэсэн санааг илтгэнэ. Монгол хэлний үгийн олноос үхрийн олон дээр гэдэг хэлцтэй утга нийтлэг юм.

腹が立つ (гэдэс босох) уурлах, уур хүрэх¹⁷

Голын эрэг дээр хүүхдүүд тоглохдоо мэлхийг барьж аван дээш нь харуулаад гэдсэн дээр нь цохиж, дуу гарган тоглоцгоодог. Энэ үед мэлхийн гэдэс хөөн дээш цүндийдэг аж. Ийнхүү мэлхий уурласнаас болж гэдэс нь дээшээ боссон буюу цүндийсэн гэдгээс энэхүү 腹が立つ(гэдэс босох) гэдэг хэлц үүссэн буюу япон хүний хувьд уур хүрэх, уурлаж ундууцах үедээ энэ хэлцийг өргөнөөр хэрэглэдэг байна. Уурласан япон хүний гэдэс нь цүндийх бус уурлаж ундууцсан санаагаа илэрхийлж буй хэрэг юм. Ингэж далай, гол усны амьтны ааш араншинг ажиглан сайтар мэдсэн нь хэлэндээ ийнхүү илэрч байна. Ер нь япон хүн хоол их идээд гэдэс бослоо, гэдэс цүндийлээ гэж ярьдаггүй, お腹が一杯 буюу гэдэс дүүрлээ гэж ярьдаг.

Биеэрээ үзэж, амсаж туулсан амьдрал нь хүний оюун ухаанд гүнзгий ул мөр үлдээдэг төдийгүй, амьдрал байдлын янз бүрийн тогтсон хэв маяг, түүнийг тэмдэглэж илэрхийлсэн хэлний баримт нь үеэс үе дамжин уламжлагдахын хэрээр тухайн хэлээр харилцагчдын сэтгэлгээний тогтсон загвар, тогтсон хэв шинж болдог зүй тогтолтой ажээ. Өөрөөр хэлбэл, үндэстний соёлын тухай мэдлэг, түүнийг илэрхийлсэн тогтвортой үг хэллэгийн утгыг зөв ойлгож тайлбарлах чадвар нь уг соёлыг эзэмших, бас юм үзэж, нүд тайлахын хэрээр төлөвшидөг болох нь харагдаж байна.¹⁸

Эндээс дүгнэхэд хэлц үгийн үндсэн шинж нь үндэсний өвөрмөц онцлог бүхий Японы түүх, домог, урлаг, спорт, эрхэлж буй аж ахуй, өдөр тутмын амьдралаас урган гарсан,

¹⁷ Л. Чулуунбаатар, Ц. Онон Япон монгол хэлний өвөрмөц хэлцийн толь – Уб., 2010, 212 тал

¹⁸ Ж. Баянсан Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ – Уб., 2002, 82 тал

орон судлалын холбогдолтой үндэсний соёлын үг хэллэг нэлээд байдаг ба утга нь гол төлөв шилжсэн байна. Монголчууд таван хошуу малаа сайн мэддэгтэй адил япончууд далайн ургамал, амьтны талаар мэдэхгүй зүйл гэж үгүй. Учир нь тухайн үндэстэн л сайн мэдэх ахуй амьдрал, соёл, ёс заншил, уламжлал, шашин шүтлэг, спорт, урлаг, түүхийн онцлогууд өргөн утгаараа өвөрмөц хэлц, хэллэгийн цаана агуулагдаж байдаг болохоор бусад хэлний нэгжүүдээс онцгой шинжээр нь өвөрмөц хэлц, хэллэг хэмээн нэрлэсэн байх. Эрдэмтэн судлаачид өвөрмөц хэлц хэллэгийн дээрх үндэсний онцлогийг судалгаандаа тодорхой хэмжээгээр дурдсан байдаг. Монгол хэлний өвөрмөц хэлц хэллэгийг бүтэц хэл шинжлэлийн хүрээнд эрдэмтэд өөр өөрийн судалгааны өнцгөөс судалсан байна. Харин олон шинжлэх ухааны уулзвар дээр буюу хэл орон судлалын чиглэлээр тусгайлан судалсан ганц сэдэвт бүтээл өнөө хэр нь гараагүй байна. Хэл, орон судлалын онцлогийг гаргахын тулд дан хэлний төдийгүй бусад орны хэлц хэллэгтэй харьцуулсан ба зэрэгцүүлсэн судалгаа хийснээр илүү сонирхолтой онцлогуудыг гаргаж ирэх боломжтой гэж үзэж байна.

Дээрх түүвэрлэсэн жишээнээс 腹 (хара) гэдэг үг давтагдаж орсон тул энэ үгийн утгыг япон үгийн тайлбар толь бичиг, мөн С.Дэмбэрэлийн “Япон-монгол толь бичигт”-ээс нягталвал: 1. гэдэс 2. хэвэл, хэвлий 3. сэтгэл зүрх, чин сэтгэл 4. санаа, сэтгэл гэж тайлбарласан байна. Толь бичиг дээрх тайлбар төдийгүй 腹 (хара) орсон өвөрмөц хэлцийн бусад давтамжийг ажиглахад япон үндэстний хувьд 腹 (хара) нь япон хүний амин газар буюу амин сүнс нь байж болох юм.

Япон, монгол хэлээр ярилцагч ард түмний оршин суугаа газар зүйн байрлал, орчин өөр өөр, амьдрал аж байдлын хэвшил, зан заншил, уламжлал, түүх, соёл, шашин шүтлэг зэрэг нь харилцан адилгүй болохоор тэдний юмс үзэгдэл, үйлдэл, ухагдахууны харилцан хамаарал, уялдаа шүтэлцээг урнаар товч илэрхийлэх хэлбэр нь өөр өөр байна. *Хэлэнд тухайн ард түмний амьдралын туршилага хадгалагдаж үлддэг учраас хэл нь ард түмний соёлыг үе үеийн хүмүүст дамжуулж өгдөг хэрэглүүр мөн.*¹⁹

НОМ ЗҮЙ

- Д.Бадамдорж. “Монгол хэлний утга судлал”. Уб., 2001
Ж.Төмөрцэрэн. “Монгол хэлний үгийн сангийн судлал”. Уб., 2001
Ж.Баянсан. “Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ”. – Уб., 2002
Эрдэм шинжилгээний бичиг, боть 170 (1), МУИС-ГХСС – Уб., 2001
Монгол хэлний үгийн сан судлал, боть 12, МУШУ – Уб., 2009
Ц.Өлзийхутаг. “Монгол хэлний үгийн сангийн судлал”. Уб., 1973
Ц.Дашдондов. “Монгол – англи өвөрмөц хэлц, хэллэгийн толь”. – Уб., 2007
Д. Дашдаваа. “Үндэсний онцлог бүхий үг, хэлц үгийг орчуулах нь”// “Орчуулах эрдэм”. Уб., 1972
Г.Аким. “Монгол өвөрмөц хэлцийн товч тайлбар толь” – Уб., 1982
Чой.Лувсанжав. “Орос монгол өвөрмөц хэллэгийн толь – Уб., 1970
Л. Чулуунбаатар, Ц. Онон. “Япон монгол хэлний өвөрмөц хэлцийн толь” – Уб., 2010
С.Дэмбэрэл. “Япон –монгол толь бичиг”-Уб., 2010

¹⁹ Эрдэм шинжилгээний бичиг, боть 170(1), МУИС-ГХСС – Уб., 2001, 12 тал